

Хөдөөаж ахуйнхоршоологчдынүндэсний холбооны

VII Их хурлын 7 дугаар тогтоолоор батлав.

## МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ДҮРЭМ

*/Шинэчилсэн найруулга/*

**НЭР:**Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо

- Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны товчилсон нэр нь МХААХҮХ байна.
- Олон улсад хэрэглэгдэх нэр “National Association of Mongolian Agricultural Cooperatives”, товчилсноор “НАМАС” байна.

**Байгуулсан он, сар, өдөр:**1967 оны 6 дугаар сарын 12-15 ны өдрүүдэд хуралдсан Хөдөө аж ахуйн нэгдэлчдийн III их хурлаас Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөл нэртэйгээр анх байгуулагдаж, 1992 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо болгон шинэчлэн зохион байгуулсан.

**ХАЯГ:** 13381 Монгол улс. Улаанбаатар-49, Энхтайваны өргөн чөлөө 18А-1

**Вэб сайт:** [www.namac.coop](http://www.namac.coop) [www.namac.mn](http://www.namac.mn)

**И-мэйл:** [info@namac.coop](mailto:info@namac.coop) [info@namac.mn](mailto:info@namac.mn)

**Фэйсбүүк:** [www.facebook.com/namac.ica](http://www.facebook.com/namac.ica)

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

**Нэгдүгээр зүйл: Нийтлэг үндэслэл**

1.1 Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо (цаашид Үндэсний холбоо гэх) нь Монгол Улсын Иргэний хуулийн гучин гуравдугаар бүлэгт зааснаар гишүүд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн ашгийн төлөө бус, улс төрийн нам, төрийн байгууллагаас хараат бус, гишүүдээрээ дамжуулан нийгэмд үйлчилдэг Төрийн бус байгууллага байна.

1.2 Үндэсний холбоо нь Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн албан ёсны залгамжлагч мөн.

1.3 Үндэсний холбооны бүтэц нь Улсын хэмжээнд Үндэсний холбоо, аймаг, нийслэлийн түвшинд аймаг, нийслэлийн холбоо, сум, дүүргийн түвшинд анхан шатны болон дундын хоршоо, аж ахуйн нэгжүүд байна.

1.4 Үндэсний холбоо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хоршооны тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн баримт бичиг болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.5 Үндэсний холбооны төв байр нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.

1.6 Үндэсний холбоо өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан бэлгэдэл, туг, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, нэрэмжит шагнал, хүндэтгэлийн дуутай байна.

1.6.1 Бэлгэдэл нь: Тариан түрүүн дэл, сүүл бүхий цагаан морийг тэмдгийн голд байрлуулж, түүний гадна талаар дэлхий ээжийг бэлгэдсэн ногоон өнгөтэй дөрвөлжин, тэнгэр эцгийг бэлгэдсэн цэнхэр хөх өнгөтэй дугуй дүрс, алтан шаргал өнгийн хүрээтэй байна. Бэлгэдлийн төв хэсэгт байрлах цагаан морины дор Үндэсний холбооны нэрийн англи товчлол НАМАС, гадна талын хүрээнд ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО гэсэн бичиглэл байна.

1.6.2 Туг: Үндэсний холбооны туг нь мөнх тэнгэрийн хөх өнгөтэй байна. Тугны нийт талбайг гурав хуваасны нэгд буюу ишин талын дэвсгэрийн төв хэсэгт Үндэсний холбооны бэлгэдлийг байрлуулна. Тугны өргөн, урт нь 1:2 – ын харьцаатай байна.

1.6.3 Хүндэтгэлийн дуу нь: Монгол Улсын Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Л.Мөрдоржийн ая, Төрийн шагналт яруу найрагч Д.Сэнгээгийн шүлэг “Эх орон” дуу байна.

1.6.4 Нэрэмжит шагнал нь:

1.6.4.1 Тэргүүн байр эзэлсэн аймаг, нийслэлийн холбоонд олгодог шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагнал;

1.6.4.2 Үндэсний холбооны тэргүүний аж ахуйн нэгжид олгодог өргөмжлөл, хүндэтгэлийн хаяг, мөнгөн шагнал;

1.6.4.3 Хоршооллын одон;

1.6.4.4 Хөдөө аж ахуйн тэргүүний хоршоологч цол тэмдэг.

1.7 Үндэсний холбоо төрийн болон төрийн бус, бусад байгууллагатай харилцахдаа хууль дээдлэх, харилцан хүндэтгэх, шударга, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчмыг баримтална.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ БҮТЭЦ

**Хоёрдугаар зүйл.** Үндэсний холбооны бүтэц нь:

2.1 Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо /цаашид **үндэсний холбоо** гэх/;

2.2 Хөдөө аж ахуйн хоршоологчдын аймаг, нийслэлийн холбоо /цаашид **аймаг, нийслэлийн холбоо** гэх/;

2.3 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүд байна.

**Гуравдугаар зүйл.** Хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний холбооны:

3.1 Алсын хараа:

3.1.1 Хөдөө аж ахуйн хоршоолол нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн нэгэн тулгуур байна.

3.2 Эрхэм зорилго:

3.2.1 Гишүүдийнхээ эрх, ашгийг дээдлэн хамгаалж, тэдний идэвхтэй үйл ажиллагаа, оролцоонд тулгуурлан хөдөөгийн эдийн засаг, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг хангахад манлайлагч байж, хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд оршино.

3.3 Зорилт:

3.3.1 Хоршооллын байгууллагын менежментийг боловсронгуй болгох;

3.3.2 Хоршооллын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх;

3.3.3 Хоршоодын эгнээг өргөтгөж, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх;

3.3.4 Хоршооллын байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

3.3.5 Төр, хоршооллын байгууллагын түншлэлийг өргөжүүлэн бэхжүүлэх;

3.4 Үндэсний холбоо нь дараах эрхийг эдэлнэ.

3.4.1 Гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалж, төрийн бүх шатны байгууллагаас гаргаж буй хууль, тогтоомж, бодлогод нөлөөлөх;

3.4.2 Хөдөө аж ахуйн хоршооллын хөдөлгөөнийг үндэсний болон олон улсын түвшинд төлөөлөх;

3.4.3 Төрийн болон төрийн бус, бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

3.4.4 Үндэсний холбооны Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих;

3.4.5 Төрийн зарим чиг үүргийг Засгийн газар, түүний бүтцийн байгууллагуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх;

3.4.6 Хоршооллын байгууллагуудын үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор дундын хоршоо, аж ахуй нэгжүүдийг байгуулж ажиллуулах;

3.4.7 Улсын хэмжээнд хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэн хөгжүүлэх, хоршоодын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого явуулах;

3.4.8 Хоршооллын хөдөлгөөн хөгжих таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого боловсруулахад оролцох;

3.4.9 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тусгай зориулалтын сан байгуулж ажиллуулах замаар дэмжих;

3.4.10 Хоршооллын хөдөлгөөний туршлага судлах, хоршоод хоорондын хамтын ажиллагаа, бизнесийг өргөтгөх чиглэлээр гадаад орны ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах;

3.4.11 Аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуйн нэгжээс санхүү, нягтлан бодох бүртгэл, бусад мэдээллийг гаргуулан авах;

3.4.12 Өмч хөрөнгө, эрх ашгаа хамгаалуулахаар шүүх болон хууль, хяналтын байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргах;

3.4.13 Монгол Улсын хууль, тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд хөдөө аж ахуйн болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулах;

3.4.14 Хууль тогтоомжид заасан бусад эрх;

3.5 Үндэсний холбоо нь дараах үүргийг хүлээнэ.

3.5.1 Хөдөө аж ахуйн хоршооллын хөгжлийн стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгож, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

3.5.2 Хоршооллын хөдөлгөөнийг өргөжүүлэн хөгжүүлэхэд үлгэрлэн манлайлж ажиллах;

3.5.3 Аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуй нэгж, хоршоологчдын нийтлэг эрх, ашгийг хамгаалах, тэдгээрийг төрийн болон бусад байгууллагуудад төлөөлөх;

3.5.4 Төрийн болон бусад байгууллагатай хөдөө аж ахуй, хоршооллын хөгжлийн асуудлаар харилцах, хоршооллын бодлого тодорхойлоход нөлөөлөх, харилцан ашигтай хамтын түншлэлийг бий болгох;

3.5.5 Аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуй нэгжүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хоршооны сургалтын гарын авлага, материал боловсруулах, хөгжлийн болон технологийн сургалт зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

3.5.6 Хоршоодыг дотоод, гадаадын бизнесийн байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй холбож зуучлах, хоршоологчдын үндэсний болон бүсийн зөвлөгөөн, үзүүлэх сургуулийг зохион байгуулж хоршоод хоорондын мэдээлэл, харилцан туршлага солилцох, хамтран ажиллах боломжийг дэмжих, хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах;

3.5.7 Аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн захиран зарцуулалтанд хяналт тавих, зөрчлийг арилгуулах, үр дүнг тайлагнах;

3.5.8 Хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

**Дөрөвдүгээр зүйл.** Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо:

4.1 Гишүүн аймаг, нийслэлийн холбоонь Үндэсний холбооны үндсэн чиг үүргийг тухайн орон нутагт хэрэгжүүлэгч байна.

4.2 Аймаг, нийслэлийн холбоонь үйл ажиллагаандаа тухайн холбооны бага хурлаас Үндэсний холбооны дүрэмд нийцүүлэн баталсан дүрмийг мөрдлөг болгоно.

4.3 Аймаг, нийслэлийн холбооны үйл ажиллагааг тухайн холбооны бага хурлаас сонгогдсон холбооны дарга удирдан зохион байгуулах бөгөөд түүнтэй Үндэсний холбооны Ерөнхийлөгчүр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

4.4 Аймаг, нийслэлийн холбооны дарга нь үр дүнгийн гэрээний биелэлтийг аймаг, нийслэлийн холбооны бага хуралд тайлагнаж дүгнүүлнэ.

4.5 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн эрх, ашигтай зөрчилдсөн аливаа үйл ажиллагаа явуулсан, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эрх мэдлээ хэтрүүлсэн аймаг, нийслэлийн холбооны даргыг хугацаанаас нь өмнө чөлөөлүүлэх саналыг тухайн холбооны бага хуралд Үндэсний холбооноос оруулж болно.

4.6 Энэхүү дүрмийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу аймаг, нийслэлийн холбооны даргыг хугацаанаас өмнө чөлөөлүүлэхээр гаргасан саналыг тухайн холбооны бага хурлын гишүүд хэлэлцэхээс татгалзсан эсвэл холбооны даргыг хэвээр үлдээхээр шийдвэр гаргасан тохиолдолд Үндэсний холбооны Ерөнхийлөгч тухайн аймаг, нийслэлийн холбооны даргатай ажил сайжруулах тодорхой хугацаатай гэрээ байгуулна.

4.7 Аймаг, нийслэлийн холбоо нь идэвхитэй үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх үүрэгтэй.

**Тавдугаар зүйл.** Гишүүн байгууллага, аж ахуйн нэгж

5.1 Үндэсний холбооны дүрэм, холбогдох журмыг хүлээн зөвшөөрч гишүүнээр элсэхийг хүссэн хоршооллын хөдөлгөөнийг дэмжигч төрийн бус байгууллага, анхан шатны болон дундын хоршоо, бусад аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр аймаг, нийслэлийн холбоонд элсэж, холбооны дүрмийн дагуу үйл ажиллагаанд оролцож зохих эрх эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

5.2 Гишүүнчлэлийн журмыг Үндэсний холбооны Удирдах зөвлөлөөс батлан, гишүүн элсүүлэх, гаргах асуудлыг аймаг, нийслэлийн холбооны Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

5.3 Гишүүн байгууллагууд нь аж ахуй, санхүү, зохион байгуулалтын бие даасан байдал, хуулийн этгээдийн эрхээ энэхүү дүрмийн хүрээнд бүрэн хадгална.

5.4 Гишүүнээр элсэхийг хүссэн хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлэн тухайн нутаг дэвсгэрийн аймаг, нийслэлийн холбоонд ирүүлнэ.

5.4.1 Гишүүнээр элсэх тухай албан хүсэлт;

5.4.2 Гишүүнээр элсэхээр шийдвэрлэсэн үүсгэн байгуулагчид болон бүх гишүүдийн хурлын шийдвэр;

5.4.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

5.4.4 Тухайн байгууллагын дүрэм;

5.4.5 Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга;

5.4.6 Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээлэл;

5.4.7 Хоршоо нь олон улсын хоршооллын зарчмын хэрэгжилтийг хэрхэн хангажбайгаа талаар мэдээлэл, танилцуулга;

5.5 Аймаг, нийслэлийн холбоо нь гишүүнээр элссэн болон гарсан хуулийн этгээдийн мэдээллийг ажлын 20 хоногийн дотор Үндэсний холбоонд ирүүлнэ.

5.6 Гишүүнчлэлийн нэгдсэн бүртгэлтэй байх ба гэрчилгээ нь аймаг, нийслэлээр тусгай кодтой байна. Гишүүнчлэлийн гэрчилгээ олгосноор эрх зүйн харилцаа үүснэ.

5.7 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгж доорх эрх эдэлнэ.

5.7.1 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооны удирдлагыг сонгох, сонгогдох, шийдвэр гаргахад оролцох;

5.7.2 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооны үйл ажиллагаа, хөгжлийн хэтийн төлвийн талаар санал гаргах;

5.7.3 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан мэдээлэлтэй танилцах;

5.7.4 Хууль ёсны эрх, ашгаа хамгаалуулж, үйл ажиллагааныхаа үр дүнг төр засгийн болон бусад байгууллага, Үндэсний холбоогоор үнэлүүлэх;

5.7.5 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооноос сургалт, мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээ авах;

5.8 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгж дараах үүргийг хэрэгжүүлнэ.

5.8.1 Хоршооны тухай хууль, Олон улсын хоршооллын зарчим, үнэт зүйлс, ёс зүйг үйл ажиллагаандаа удирдлага болгох;

5.8.2 Үндэсний холбооны дүрэм, удирдах байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

5.8.3 Хоршооллын хөдөлгөөнийг манлайлах, сурталчилах, дэмжих, түгээн дэлгэрүүлэх;

5.8.4 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгж бүр Үндэсний холбооны Удирдах зөвлөлөөс баталсан нэгдсэн нэг бэлэгдэл, хэвлэмэл хуудас хэрэглэх;

5.8.5 Үндэсний холбооны Удирдах зөвлөлөөс тогтоосон гишүүнчлэлийн татвар, хураамжийг хугацаанд нь төлөх;

5.8.6 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбоонд тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн ирүүлэх;

5.8.7 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооноос зохион байгуулж буй сургалт, зөвлөгөөн, бусад үйл ажиллагаанд идэвхи, санаачилгатай оролцох;

5.8.8 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооноос хэрэгжүүлж буй хяналт шалгалтанд хамрагдах, үүнд шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх, илэрсэн зөрчлийг арилгах;

5.8.9 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооны хяналтын зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлж, тайлагнах;

5.9 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх хариуцлага.

5.9.1 Энэхүү дүрмийн 5.8 дугаар зүйлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд

5.9.1.1 Хугацаатай үүрэг өгөх;

5.9.1.2 Үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

5.9.1.3 Гишүүнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

5.10 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгж нь сайн дураараа гишүүнээс гарч болно. Гишүүнээс гарах хүсэлтээ, гарах болсон үндэслэл бүхий албан ёсны шийдвэрийн хамт харьяалагдах аймаг, нийслэлийн холбоонд хүргүүлнэ.

5.11 Гишүүнээс гарах хүсэлт нь аймаг, нийслэлийн холбооны Тэргүүлэгчдийншийдвэр гарснаар хангагдана. Гишүүнээс гарсан нөхцөлд гишүүний татвар, бусад хураамжийг буцаан олгохгүй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**Зургаадугаар зүйл. Үндэсний холбооны зохион байгуулалтын бүтэц**

6.1 Зохион байгуулалтын бүтэц:

- 6.1.1 Их хурал
- 6.1.2 Хяналтын зөвлөл
- 6.1.3 Удирдах зөвлөл

**Долоодугаар зүйл: Үндэсний холбооны Их хурал**

7.1 Үндэсний холбооны удирдах дээд байгууллага нь дөрвөн жилд нэг удаа хуралддаг Их хурал байна.

7.2 Сонгогдсон төлөөлөгчдийн дийлэнхи олонх нь хүрэлцэн ирсэнтохиолдолд Их хурал хүчин төгөлдөр болно.

7.3 Их хурлын төлөөлөгчдийн тоог Үндэсний холбооны Удирдах зөвлөлөөс тогтоож, аймаг, нийслэлийн холбооны бага хурлаас сонгоно.

7.4 Үндэсний холбооны дүрэм батлах, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, Үндэсний холбооны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх асуудлыг Их хуралд оролцсон төлөөлөгчдийн дөрөвний гурваас доошгүй хувийн саналаар, бусад асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.5 Их хурал хуралдуулах товыг 90-ээс доошгүй хоногийн өмнө Удирдах зөвлөлийн хурлаас тогтоож, гишүүн холбоодод мэдэгдэнэ.

7.6 Үндэсний холбооны ээлжит бус Их хурлыг Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн санал, Хяналтын зөвлөлийн шаардлагын үндсэн дээр хуралдуулж болно.

7.7 Үндэсний холбооны Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

- 7.7.1 Үндэсний холбооны дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 7.7.2 Үндэсний холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;
- 7.7.3 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
- 7.7.4 Үндэсний холбооны Ерөнхийлөгчийг сонгох;



7.7.5 Үндэсний холбооны Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийн тоог тогтоож, бүрэлдэхүүнийг сонгож, батлах;

7.7.6 Үндэсний холбооны үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах;

7.7.7 Үндэсний холбооны үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудал;

### **Наймдугаар зүйл. Үндэсний холбооны Хяналтын зөвлөл**

8.1 Хяналтын зөвлөлийг 5 буюу түүнээс дээш гишүүнтэйгээр, Үндэсний холбооны Их хурлаас дөрвөн жилийн хугацаатай сонгоно.

8.2 Хяналтын зөвлөлийн дарга, орлогч даргыг гишүүдийн дотрооснууц санал хурааж, олонхийн саналаар сонгоно.

8.3 Хяналтын зөвлөл нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

8.3.1 Үндэсний холбооны дүрэм, Их хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулах;

8.3.2 Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, үүний тулд шаардагдах баримт бичгийг гаргуулан авах, мэдээлэл илтгэл сонсох, нягтлан бодох бүртгэл, бусад бичиг баримттай танилцах;

8.3.2 Аймаг, нийслэлийн холбоо, гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, төсөв, санхүүд төлөвлөгөөт болон захиалгат хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчлийг арилгуулах;

8.3.3 Үйл ажиллагааныхаа үндсэн чиг үүргийн асуудлаар журам, зөвлөмж гаргах;

8.3.4 Шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийн болон Үндэсний холбооны ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулах тухай санал гаргах;

8.3.5 Дүрэм журмаар олгогдсон бусад эрх, үүрэг;

8.4 Хяналтын зөвлөл хяналт шалгалтын талаарх мэдээлэл, дүгнэлтээ Удирдах зөвлөлд танилцуулна.

8.5 Хяналтын зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд тухайн асуудлаар хариуцлага тооцох эрх бүхий этгээдэд хандаж шийдвэрлүүлнэ.

8.6 Хяналтын зөвлөлийн гишүүдийг үндсэн үүргээ гүйцэтгэх хугацаанд Үндэсний холбооны дотоод журмын дагуу албан томилолтын болон унааны зардлыг Үндэсний холбооноос олгоно.

**Есдүгээр зүйл. Үндэсний холбооны Удирдах зөвлөл**

9.1 Үндэсний холбооны Удирдах зөвлөлийг 51-ээс доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр Их хурлаас дөрвөн жилийн хугацаатайгаар сонгоно.

9.2 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Үндэсний холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, аймаг, нийслэлийн холбоодын дарга нарыг шууд, бусдыг аймаг, нийслэлийн холбооны бага хурлын саналыг харгалзан ардчиллын зарчмаар Их хуралд оролцсон төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар сонгоно.

9.3 Удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч, түүний эзгүй үед Дэд Ерөнхийлөгч удирдана.

9.4 Удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй ба асуудлыг хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9.5 Удирдах зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүйд хүрвэл тухайн аймаг, нийслэлийн холбооны бага хурлын саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн хурлаар чөлөөлж, нөхөн сонгож болно.

9.6 Удирдах зөвлөл нь Их хурлын чөлөөт цагт Үндэсний холбооны дүрэм, Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдана.

9.7 Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн санал, Хяналтын зөвлөлийн санаачилгаар зарлан хуралдуулж болно.

9.8 Удирдах зөвлөл нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

9.8.1 Үндэсний холбооны ээлжит Их хурлын хооронд Үндэсний холбооны үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

9.8.2 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбооны үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм, журмыг батлан мөрдүүлэх;

9.8.3 Үндэсний холбооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, нэгдсэн төсвийг хэлэлцэн батлах;

9.8.4 Үндэсний холбооны жилийн үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэлэлцэх, Хяналтын зөвлөлийн мэдээллийг сонсох, дүгнэлт гаргах;

9.8.5 Гишүүнчлэлийн татвар, хураамжийн хэмжээг тогтоох;

9.8.6 Үндэсний холбооны ээлжит болон ээлжит бус Их хурлын товыг тогтоох, зарлах, төлөөлөгчдийн тоог тогтоох, хэлэлцэх асуудлыг батлах;

9.8.7 Үндэсний холбооны ажлын албаны бүтэц, орон тоо, түүний төсвийг батлах;

- 9.8.8 Үндэсний холбооны Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн Дэд Ерөнхийлөгчийг сонгох;  
9.8.9 Үндэсний холбооноос гадаад оронд ажиллах төлөөлөгчийн газар болон түншлэгчийг сонгох;

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ УДИРДЛАГА**

### **Аравдугаар зүйл: Удирдлагын бүтэц:**

- 10.1 Ерөнхийлөгч
- 10.2 Дэд Ерөнхийлөгч
- 10.3 Гүйцэтгэх захирал
- 10.4 Хэлтэс, ажлын алба

### **Арван нэгдүгээр зүйл. Үндэсний холбооны Ерөнхийлөгч, түүний эрх үүрэг**

11.1 Үндэсний холбооны Ерөнхийлөгчийг Их хурлаас дөрвөн жилийн хугацаатай сонгоно

11.2 Үндэсний холбооны Ерөнхийлөгч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

- 11.2.1 Үндэсний холбооны Ерөнхийлөгч холбооны дүрмийн дагуу гишүүдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- 11.2.2 Төр, засгийн хууль, тогтоомж, шийдвэрт Үндэсний холбооны байр суурийг илэрхийлж оролцох;
- 11.2.3 Ерөнхийлөгч Үндэсний холбооны бодлого, стратегийг Их хурлаар хэлэлцүүлэх, түүний биелэлтийг тайлагнах;
- 11.2.4 Үндэсний холбоог төлөөлж төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, бусад аж ахуйн нэгжтэй харилцах;
- 11.2.5 Үндэсний холбооны Удирдах зөвлөлийн хурлынтов, хэлэлцэх асуудлыг баталж 30-аасдоошгүй хоногийн өмнө Удирдах зөвлөлийн гишүүдэд мэдэгдэх;
- 11.2.6 Үндэсний холбоог төлөөлж олон улсын уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцох төлөөлөгчийг сонгох;
- 11.2.7 Удирдах зөвлөл, Дэд Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Их хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 11.2.8 Үндэсний болон аймаг, нийслэлийн холбоод, гадаадад суугаа төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг удирдлагаар хангах;

11.2.9 Шагнал, урамшуулал, тэтгэмж, тусламж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шийдвэрлэх;

11.2.10 Гишүүн холбоод болон дэргэдэх аж ахуйн нэгжүүдийн удирдлагын ажил үүргийн хуваарийг баталж, тэдэнтэй гэрээ байгуулан ажиллах;

11.2.11 Ерөнхийлөгч эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

11.3 Үндэсний холбооны Ерөнхийлөгч хүндэтгэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Үндэсний холбооны Дэд Ерөнхийлөгч дараагийн Их хурал хүртэл үүрэгт ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

### **Арван хоёрдугаар зүйл. Үндэсний холбооны Дэд Ерөнхийлөгч, түүний эрх үүрэг**

12.1 Үндэсний холбооны Дэд Ерөнхийлөгчийг, Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөлийн хурлаас 4жилийн хугацаатай сонгоно.

12.2 Дэд Ерөнхийлөгч нь доорх эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12.2.1 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөх, Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, Удирдах зөвлөлд тайлагнах;

12.2.2 Үндэсний холбооны ажлын алба, гишүүн холбооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих;

12.2.3 Удирдах зөвлөлөөс баталсан төсвийг бүрдүүлэх, захиран зарцуулахад нэгдүгээр гарын үсэг зурах, гүйцэтгэлд хяналт тавих;

12.2.4 Удирдах зөвлөлийн гишүүдийг удирдлага, мэдээллээр хангах;

12.2.5 Хяналтын зөвлөлөөс өгсөн зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих;

12.2.6 Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн эрх хэмжээнд хамааруулаагүй бусад асуудлыг шийдвэрлэх;

12.3 Дэд Ерөнхийлөгч эрхээ хэтрүүлсэн болон үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөл хугацаанаас нь өмнө чөлөөлж болно.

### **Арван гуравдугаар зүйл. Үндэсний холбооны Гүйцэтгэх захирал**

13.1 Ерөнхийлөгч Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж ажиллана.

13.2 Гүйцэтгэх захирал нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн шууд удирдлаган дор гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

13.3 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг гэрээгээр зохицуулна.

13.4 Гүйцэтгэх захирал нь өөрийн гэрээний

хугацаа дууссан нөхцөлд шинээр гүйцэтгэх захирлыг томилох хүртэл албан үүргээ хэвээр гүйцэтгэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ӨМЧ ХӨРӨНГӨ**

**Арван дөрөвдүгээр зүйл.** Үндэсний холбоо дүрмэндээ заасан эрх, үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн өмч хөрөнгөтэй байна.

14.1 Үндэсний холбоо нь Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн хөрөнгийг хууль ёсоор залгамжилсан өмчлөгч мөн.

14.2 Үндэсний холбооны эд хөрөнгө нь халдашгүй бөгөөд түүний өмчлөгчийн эрх нь хуулиар хамгаалагдана.

14.3 Үндэсний холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хуульд зааснаар өвлөж авсан, өөрийн үйл ажиллагааны үр дүндбий болгосон үндсэн болон эргэлтийн хөрөнгийг өмчлөгч, тогтоосон хэмжээний газрыг эзэмшигч мөн.

14.4 Аймаг, нийслэлийн холбоо нь тухайн холбооныхоо хөрөнгийг өмчлөгч, газрыг эзэмшигч байна.

14.5 Үндэсний холбооны албан ёсны зөвшөөрөлгүйгээр үндэсний болон аймаг, нийслэлийн холбооны өмч хөрөнгийг бусдад барьцаалах, худалдах, бэлэглэхийг хориглоно.

14.6 Аймаг, нийслэлийн холбооны өмч хөрөнгө, газрыг өмчлөх, эзэмших, захиран зарцуулах асуудлыг тусгай журмаар зохицуулах ба журмыг Үндэсний холбооны Удирдах зөвлөлийн хурлаас батална.

14.7 Үндэсний холбооны өмч дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ.

14.7.1 Үндэсний холбооны өвлөн авсан хөрөнгө

14.7.2 Гишүүнчлэлийн татвар

14.7.3 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого

14.7.4 Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв, хандивлагч байгууллагуудаас олгосон хөрөнгө

14.7.5 Бусдад нийлүүлсэн хувь хөрөнгө болон хөрөнгө эзэмших эрх, ногдол ашиг, худалдаж авсан хувьцаа, зээлийн хүү

14.7.6 Хандив тусламж

14.7.7 Бусад эх үүсвэр

14.8 Үндэсний холбооны санхүүгийн жилийг хуанлийн жилээр /1-р сарын 1-ний өдрөөс 12-р сарын 31-ний өдрийг дуустал хугацаа/ тооцно.

14.9 Үндэсний холбоо нь жилийн санхүүгийн тайланг Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу татварын албанд гаргаж өгнө.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

### ҮНДЭСНИЙ ХОЛБООГ

### ӨӨРЧЛӨН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

**Арван тавдугаар зүйл.** Үндэсний холбоог өөрчлөн зохион байгуулах асуудлыг зөвхөн Үндэсний холбооны Их хурлаар шийдвэрлэнэ.

**Арван зургаадугаар зүйл.** Үндэсний холбоог татан буулгах шийдвэр гаргасан тохиодолд татан буулгах комисс байгуулж, уг ажлыг гүйцэтгүүлнэ.

16.1 Татан буулгах комисс нь дараах ажлыг зохион байгуулна:

16.1.1 Хөрөнгийн нэгдсэн тооллого явуулж, дүнг гаргах;

16.1.2 Үндэсний холбоотой холбогдсон төлбөр, тооцоог барагдуулж дуусгах;

16.1.3 Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах;

16.1.4 Үндэсний холбооны дуусгалтын тайлан тэнцлийг гаргаж, зохих байгууллагуудад хүлээлгэж өгөх;

**Арван долоодугаар зүйл.** Үндэсний холбооны бүх хөрөнгөнөөс төлбөр тооцоог барагдуулж үлдсэн хөрөнгийг тухайн үед ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

— — — о Оо — — —